



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/545

Номгон

Г Сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, чадавхжуулах сургалт зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/55 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 1.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, чадавхжуулах сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулахад хөрөнгө зарцуулсугай.


2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, чадавхжуулах сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 3 000 000 (Гурван сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Зөвлөн туслах, чадавхжуулах сургалтыг чанартай зохион байгуулж ажиллахыг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл (Д.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

64231141?

D:\2023 on\захирамж-2023\Захирамж-2023++++.docx

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын
11-ний өдрийн 11545 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

УДИРДАМЖ

Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд
зөвлөн туслах, чадавхжуулах сургалт
зохион байгуулах тухай

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах сурталчлах, сумдын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, зөрчлийг арилгуулах, гишүүдийг чадавхжуулах.

Хоёр. Удирдамжийн зорилго

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль болон бусад холбогдох эрхзүйн актуудын хэрэгжилтийг сайжруулах, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хяналт болон ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангахтай холбоотой мэдлэгийг салбар зөвлөлийн гишүүд болон сумдын албан байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүдэд мэдлэг олгох.

Гурав. Хүлээгдэж буй үр дүн

1. Сумуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө мэдээлэл өгөх, салбар зөвлөлд чадавхжуулах сургалт зохион байгуулах.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажлыг үнэлж, зөвлөгөө мэдээлэл өгөх

Дөрөв. Хугацаа, ажлын хэсгийн бүрэлдэхүүн

2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэл бүсчлэн зохион байгуулна.

Говийн бүс:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхжаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга

Гишүүд: Л.Намжилмаа-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

2.

Ж.Дуламсүрэн-Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

Ө.Төгсгэрэл-Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

Хангайн бүс:

Ажлын хэсгийн ахлагч: В.Гүрсэд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд: Э.Батцэцэг-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

Д.Сосорбурам- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга

Д.Чимгээ-Ажил олгогч эздийн төлөөлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн

Тав. Хамрах хүрээ

Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнууд, ажилтан, албан хаагчид

Зургаа. Удирдамжийн дагуу байгууллагуудад зохион байгуулагдах ажил, үйлчилгээ

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн төлөвлөсөн ажлууд түүний хэрэгжилт
- Аж ахуйн нэгж байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнууд, ажилтан албан хаагчдад сургалт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар зөвлөн туслах үйлчилгээ

Аймгийн Засаг даргын ^{10/23} оны 10 дугаар сарын
11-ний өдрийн ¹⁵⁹⁵ дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

СУМДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗӨВЛӨН ТУСЛАХ, ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нийт /төгрөг/
1	2	3	4
1	Хангайн бүсийн сумдад зөвлөн туслах, чадавхжуулах сургалт зохион байгуулахад шаардагдах шатахуун	Литр	900.000
2	Говийн бүсийн сумдад зөвлөн туслах, чадавхжуулах сургалт зохион байгуулахад шаардагдах шатахуун	Литр	900.000
3	Урамшуулал /6 хүн 10 хоног ажиллана/	төг	1.200.000
Дүн			3.000.000

_____ ооо _____